

**НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН МЭДЭЭЛЭЛ АШИГЛАХЫГ
ХЯЗГААРЛАХ, МЭДЭЭЛЭЛ УСТГАХ, МЭДЭЭЛЛИЙН ЭЗНИЙГ
ТОДОРХОЙЛОХ БОЛОМЖГҮЙ БОЛГОХ ЖУРАМ**

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар Нийслэлийн өмчийн харилцааны газар / цаашид “Газар” гэх/-т хувь хүний болон мэдээллийн аюулгүй байдал, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор ажиллаж байгаа дүрсний төхөөрөмж /камер/-өөр бичигдсэн видео мэдээллийг ашиглахад хязгаарлалт хийх, устгах, дүрсэнд бичигдсэн мэдээллийг эзнийг тодорхойлох боломжгүй болгох харилцааг зохицуулна.

1.2. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.4-ийг үндэслэн энэ журмыг боловсруулав.

1.3. Журмын хэрэгжилтэд Газрын дарга хяналт тавина.

**ХОЁР. Мэдээлэл ашиглахыг хязгаарлах, устгах, мэдээллийн эзнийг
тодорхойлох боломжгүй болгох**

2.1. Газрын даргаас бусад албан хаагчид болон иргэд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөнөөс бусад тохиолдолд камерын бичлэгийг шууд болон ухрааж үзэх, түүнтэй танилцах боломжгүй.

2.2. Газрын даргын зөвшөөрснөөр энэ талын мэргэжилтэн /Программист, сүлжээний инженер/, гаднын бусад мэргэжлийн этгээд камерын бичлэгтэй танилцахад журмын 2.1 хамаарахгүй.

2.3. Мэдээллийн эзэн камерын бичлэгийн өөрт хамааралтай буюу эрх, хууль ёсны ашиг сонирхлыг нь хамгаалах боломжтой гэж үзсэн хэсгийг хуулбарлан гаргуулах, бичиж авах тохиолдолд холбогдох мэргэжилтэн /Программист, сүлжээний инженер/ тухайн бичлэгт байх гуравдагч этгээдийг танигдах боломжгүй болгоно.

2.4. Журмын 2.3-т заасан тохиолдолд тухайн дүрс бичлэг гуравдагч этгээдийг бичээгүй бол мэргэжилтэн /Программист, сүлжээний инженер/ нэмэлт ажиллагаа хийх шаардлагагүй.

2.5. Шүүх эрх мэдлийн болон хууль хяналтын байгууллагууд /ТЕГ, АТГ, ЦЕГ, Прокурорын байгууллага зэрэг/-ийн шаардсан хэлбэрээр камерын бичлэгийг гаргаж өгнө.

2.6. Энэ журам, холбогдох хууль тогтоомжоор зөвшөөрснөөс бусад тохиолдолд камерын бичлэгтэй хэн ч сайн дураар танилцах боломжгүй.

2.7. “Камерын дүрс бичлэг”-ийг устгахад санаатайгаар гар ажиллагаагаар гүйцэтгэхгүй ба мэдээлэл хадгалагдах хэмжээ дүүрсэн тохиолдолд “устах”, улмаар “бичих” гэсэн системийн автомат байдлыг ашиглана.

ГУРАВ. Бусад

3.1. Энэ журмыг зөрчиж камерын дүрс бичлэгтэй танилцсан буюу танилцахаар оролдсон, түүнийг устгасан буюу устгахаар завдсан албан хаагчид Газрын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

3.2. Журмын 2.2-т заасан үйл ажиллагаанд хамаарах зардлыг Газар хариуцна.